

Цэндийн Баттулга[✉]¹Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх ухааны сургууль, Ази судлалын тэнхим

Хар хороотын бичээсийг нягтлахад

Товчлол. Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Баянбүрд багийн нутаг Хар хороотын бичээсийг дахин нягталлаа. Зарим үсэг тэмдэгтийг ташаарч хуулснаас судалгаа мадагтай болсон байна. Хар хороотод $\text{ᠬᠢᠷᠬᠣᠷᠣᠲᠤᠨᠪᠢᠴᠡᠭᠡᠰᠢᠢᠭᠦ}$ ~ *yätmis ara on baši bitidim* ~ Йэтмиш апад [зориулж] аравтын дарга бичив би гэсэн ганц мөр бичээс байх ажээ. Бичээсийг тусгайлан хүрээ татаж бичсэн байх ба Монголын руни бичгийн бага дурсгалуудаас зорилготойгоор хүрээ татаж бичсэн бичээс одоогоор Хар хороотоос өөр байхгүй байна. ᠮᠢᠶ᠋ᠢᠨᠠᠭᠤ *yätmis ara* гэх язгууртан тэнгэрт хальсанд, түүнд зориулж үйлдээд хойлго, оршуулгад зориулсан болохыг хүрээгээр төлөөлүүлсэн байх магадлалтай. Нас барсныг хүрээ, хашлагаар төлөөлүүлэх нь хүн төрөлхтний соёлын нийтлэг хэв шинж бөгөөд аль ч соёлд түгээмэл байдаг тэмдэг, тэмдэглэгээ билээ.

Өөрөөр хэлбэл, аян замын зуур тэнгэрт хальсан Йэтмиш апа-д тахилын онгон байгуулах боломж, цаг зав байсангүйд чандарлан оршуулаад аравтын дарга бичээс үйлдсэн байж болох юм. Хар хороотын хаданд Түрэг, Уйгурын үед холбогдох өөр тамга тэмдэг ганц ч байхгүй байгаа нь бичээс үйлдэгчид маш богино хугацаагаар түр буудалласан, мөн онцгой тохиолдлоор бичээс бичиж үйлдсэн болохыг харуулна. Он цагийн хувьд Хар хороотын бичээс Уйгурын үед холбогдох нь тодорхой байна.

Түлхүүр үг. *Баянхонгор аймаг, Бууцагаан сум, Хар хороот, руни бичиг, тамга*

Battulga Tsend[✉]¹Department of Asian Studies, Faculty of Humanities, School of Arts and Sciences, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

Re-examination of the Khar khoroot inscription

Abstract. The inscriptions of Khar Khoroot, Bayanbürd Bag, Buutsagaan Sum, Bayankhongor Province, were re-examined. A few characters and letters were inadvertently copied. There is a single line of inscription in the Khar Khoroot that says, “ $\text{ᠬᠢᠷᠬᠣᠷᠣᠲᠤᠨᠪᠢᠴᠡᠭᠡᠰᠢᠢᠭᠦ}$ ~ *yätmis ara on baši bitidim* ~ I, the corporal, wrote for Yetmish Apa”. Except for Khar Khoroot, none of the Mongolian runic monuments have intentionally drawn boundaries. The inscription on Khar Khoroot is unique in this regard. Upon the demise of a nobleman named ᠮᠢᠶ᠋ᠢᠨᠠᠭᠤ *Yätmis Apa*, an inscription was crafted in his honor. The framing of the inscription might serve as a symbolic indication of its intended purpose for a funeral. Depicting deceased individuals through the use of frames and fences is a prevalent practice in human societies, serving as a universal emblem and symbol throughout cultures. Put simply, Yetmish Apa, who died while traveling, was unable to construct a sacrificial complex due to lack of chance or time. As a result, they were burned, and a commemorative inscription was made. The absence of any other stamp associated with the Turkic and Uighur periods on the Khar Khoroot rock indicates that the scribes had a brief presence and only inscribed on specific occasions. Chronologically, it is clear that the Khar Khoroot inscription belongs to the Uighur period.

Keywords. *Bayankhongor province, Buutsagaan soum, Khar Khoroot, runic inscription, seal*

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Баянбүрд багийн төвөөс холгүй байх Аав Богд уулаас зүүн талд, Уртын булгийн адаг Улаан хошууны Хар хороот хэмээх газар малчин сумын заан (аймгийн начин болсон) Сааралын Ганболдын хаваржааны арын хаданд байсан руни бичгийн дурсгалыг ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ажилтан эрдэм шинжилгээний ажилтан Б.Анхбаяр, гэрээт ажилтан Б.Буян-Орших нар 2022 оны 9 дүгээр сард судлан тодорхойлж, улмаар БНХАУ-ын Өвөр Монголын их сургуулийн багш профессор Боржигдай Мөрөн хамтран судалгааны өгүүлэл хэвлүүлжээ [Анхбаяр нар., 2023: 81].

Тус өгүүлдэд бичээсийг
 ※×hᠱᠢᠰᠢᠳᠢᠮᠢᠬᠡᠬᠡᠢᠷᠢᠭᠤᠨ
 altun basit tidim - Далан
 алтан зоос дэлдэв би
 (Олон алтаар төгрөг хийв
 би) гэж уншсан байна
 [Анхбаяр нар., 2023: 81]

Хар хороотын
 бичээсийг нягтлахад,
 M p a үсгийг нийлүүлж
 M lt, ᠠ b үсгийг ᠳ T
 үсэг тэмдэгтийг тус тус
 ташаарч хуулсанаас
 уншлага судалгаа
 мадагтай болжээ. Тиймээс
 бид уг бичээсийн талаар
 дахин өгүүлж байна.

Бидний судалгаа

Хээрийн судалгааны
 тайланд ‘Бичээсийг
 баруун урагш харсан 100
 см өндөр, 40 см өргөн, ~
 55 см хар хүрэн хүрмэн
 хадны оройгоос 16 см зайтай хөндлөн зураас
 шугам татсан байх бөгөөд шугамын урт 13 см.
 Хөндлөн шугамын доор хадны зүүн захаас 16
 см зайд иштэй онги тамгыг томоор, түүний доор
 янгир тамгыг харьцангуй жижгээр сийлжээ.
 Тэрхүү тамганаас 4.5 см зайтай, бичээс бүхий
 хадны зүүн захаас 7-8 см, баруун захаас 25 см
 орчим зайтай доод хэсгээрээ задгай дөрвөлжин
 тиг шугам татаж түүний дотор бичээсийг дээрээс
 доош бичсэн ажээ. Хар хороотын бичээсийн
 мөрийн урт 62 см, үсэг тэмдэгтийн өндөр 7-7.5 см.
 Нийт 15 үсэг тэмдэгтээс бүтэх уг бичээст шууд
 холбогдох хоёр тамга, мөн дам холбогдох нэг
 тамга байх ажээ (Зураг 1).

Бичээсийн баруун талд томоор сийлсэн
 иштэй онги бичээсийг зориулсан язгууртны,
 харин янгир тамга бичээчийнх байж болох юм.
 Харин тиг шугамаас гадна, бичээсийн эхэнд байх
 жижиг онгон тамга бичээст шууд холбогдох нь
 эргэлзээтэй тул бид дам холбогдох тамга хэмээн
 тойдорхойлж байна. Иштэй онги тамганы онги 11
 см, иштэйгээ 20 см. Янгир тамга 8 см × 6.5 см,
 хөндлөн зураасны дээр байх онги тамга 4 см × 4
 см хэмжээтэй’ [Баттулга, 2023] хэмээн дурдсан
 буй.

Бичээсийн эхийн сийрүүлгэ


※×hᠱᠢᠰᠢᠳᠢᠮᠢᠬᠡᠬᠡᠢᠷᠢᠭᠤᠨ

Үсгийн галиг: y t m s p a W N B ᠱ i b t d m

Үгийн галиг: yātmiš ara on baši bitidim

Үгчилсэн орчуулга: Йэтмиш апа аравтын дарга
 бичив би

Утгачилсан орчуулга: Йэтмиш апад [зориулж]



Зураг 1. Хар хороотын руни бичээсийн гэрэл болон гар зураг

аравтын дарга бичив би

Монгол нутгаас апа цолтонд холбогдох нэг,
 хоёр мөр бичээс хэдхэн илэрснээс Өвөрхангай
 аймгийн төв Арвайхээрийн музейд хадгалагдаж
 байгаа Өвөрхангайн бичээст ‘※×hᠱᠢᠰᠢᠳᠢᠮᠢᠬᠡᠬᠡᠢᠷᠢᠭᠤᠨ
 āk ara: bitidim - Бэк Апа: бичив би’ (Баттулга Ц,
 2022b, pp: 184–185; Болд Л, 1987, 2006, p: 257),
 Өмнөговь аймгийн Ханбогд сумын Байшинтын
 Харын бичээст ‘Mᠶᠱᠢᠳᠢᠮᠢᠬᠡᠬᠡᠢᠷᠢᠭᠤᠨ
 bitidim: balamaš (balamiš) ara - Бичив би: Баламаш (Баламиш) Апа
 бичив би’ [Аззаяа, 2021; Амартүвшин нар, 2019:
 182–183; Баттулга 2022: 97–99; Осава нар, 2020]
 Говь-Алтай аймгийн Бигэр сумын Алтан хадны
 гуравдугаар бичээс ‘Mᠶᠱᠢᠳᠢᠮᠢᠬᠡᠬᠡᠢᠷᠢᠭᠤᠨ
 ālnäg (ālnig) ara Элнэг (Элниг)’ [Баттулга, 2022: 105–106] Бугат
 сумын Онгоцын хөндийн бичээст ‘Mᠶᠱᠢᠳᠢᠮᠢᠬᠡᠬᠡᠢᠷᠢᠭᠤᠨ
 āk ara -Бэк Апа’ [Баттулга, 2022: 115–116] хэмээн тус
 тус тэмдэглэжээ. Апа цолтон өөрөө бичсэн гурван
 ч бичээс буйг дурдсан жишээнээс харж болно.

Түрэгийн язгууртны цол хэргэмийн дэс дарааг
 хятад сурвалжид 特勤 (tigin), 设 (šad), 屈律啜 (küli
 čur), 阿波 (ara) (“突厥上, n.d.) гэж тэмдэглэсэнээс
 Апа цол дөрөвдүгээрт дурдагджээ. Хаант төрийн
 дөрөвдүгээрт жагсах цолтон аравтын дарга байх
 боломжгүй учир Mᠶᠱᠢᠳᠢᠮᠢᠬᠡᠬᠡᠢᠷᠢᠭᠤᠨ yātmiš ara- Йэтмиш апа
 цолтонд зориулж Mᠶᠱᠢᠳᠢᠮᠢᠬᠡᠬᠡᠢᠷᠢᠭᠤᠨ on baši-Аравтын дарга
 бичсэн гэдэг нь тодорхой болж байна.

Хар хороотын энэхүү бичээс загвар, агуулгын
 хувьд Дундговь аймгийн Говь-Угтаал сумын
 нутагт дахь Их Бичигтийн ※×hᠱᠢᠰᠢᠳᠢᠮᠢᠬᠡᠬᠡᠢᠷᠢᠭᠤᠨ
 boz qunci (aqunči) on baši bitidim - Боз Кунчи
 (Акунчи) аравтын дарга бичив би’ хэмээх
 бичээстэй таарч байна.

Боз Кунчи (Акунчи) нэрийн тухайд доктор
 Б.Аззаяа “Эрдэмтэн М.Шинэхүү гуай

Хар балгасын II бичээст ᠶᠡᠨ гэж буйг ᠶᠡᠨ $\sim\text{QWnc}\sim\text{qunc}\sim$ Кунч хэмээн галиглаж утгачлан Кунчи (Акунчи) гэж орчуулсан нь Их бичигтийн дурсгалын ᠶᠡᠨ $\sim\text{QWnci}\sim\text{Quncici}$ (Aquncici)-тай хэлбэрийн ерөнхийдөө дүйж байна. Хэдий тийм боловч тус хоёр дурсгалд нэр тэмдэглэгдсэн Quncici (Aquncici) нэг хүн үү эс бөгөөс огт холбоо хамааралгүй хоёр өөр хүний нэр дурдагдаж байна уу гэдгийг тогтоох боломжгүй. Гэхдээ Хар балгасын II бичээс дээрх хоёр тамга Их бичигтийн дурсгалын баруун талд харьцангуй томоор цохисон хоёр тамгатай тун ижил байгаа нь нэг овог аймгийнх, цаашлаад нэг хүн байж болохыг батлах баримт гэж болох ч харамсалтай нь хангалттай үндэслэл болохгүй. Их бичигтийн дурсгалд Боз Кунчи (Акунчи) аравтын дарга, Хар балгасын II бичээст Кунчи (Акунчи) буюук гэж хэргэм цолоороо ялгагдана. Энэ ялгаанаас үзэхэд хоёр өөр хүн байх магадлалтай юм. Хэрэв зээ нэг хүн хэмээн үзвэл өмнө аравтын дарга байгаад хожим “буюук” цол хүртсэнийхээ хойно хөшөө дурсгалаа босгосон байж болно” [Аззаяа, 2018; Баттулга, 1997; 2022: 85–87] гэж тэмдэглэжээ. Тус бичээст буюук гэж бичсэн нь буюрук цолын бичлэгийн нэг хувилбар гэж үздэг.

Хар балгасын хоёрдугаар хөшөөнд буй хоёр тамга Их Бичигтийн бичээсийн тамгатай дүрсийн ямар нэгэн хувирал өөрчлөлтгүй адилхан, яв цав таарч байгаа нь тохиолдлын зүйл биш бөгөөд Кунчи (Акунчи) гэх цэргийн захирагч язгууртанд холбогдох бичээс мөн болохын баталгаа гэлтэй.

Цэргийн анги, нэгтгэлийн хамгийн бага нэгж болох ᠶᠡᠨ on baši – аравтын дарга’ нар хүртэл бичгийн боловсролтой байсныг Хар хороот, Их бичигтийн бичээс гэрчлэхийн зэрэгцээ руни бичгийн хэрэглээ хэр өргөн дэлгэр байсныг харуулах нэгэн баримт юм.

Хар Хороотын бичээсийн ᠶᠡᠨ yätmis ара - Йэтмиш апа нэрийн ᠶᠡ ара - Апа цол, харин ᠶᠡᠨ yätmis – Дал (Далт, Далантай) гэх утгатай нэр мөн үү гэдэг нь тун сонирхолтой. Хэрвээ тооны нэрээс үүссэн нь баттай бол руни бичгийн дурсгалд анх удаа тооны нэрээс бүтсэн хүний нэр дурдагдаж буй шинэ баримт болно. Жарантай, Далантай, Наянтай, Ерэнтэй гэх мэт нэр монголчуудын дунд түгээмэл байдаг. Харин эртний Түрэг, Уйгурын үед ийм нэр байсан уу гэвэл руни бичгийн дурсгал төдийгүй Уйгурын хууль цаазын уйгур бичгийн бидний үзсэн сурвалжуудад энэ мэт тоогоор нэрлэсэн хүний нэр одоогоор олдсонгүй, түгээмэл нэр биш учраас тэмдэглэгдээгүй ч байх талтай.

ᠶᠡᠨ yätmis – Дал (Далт, Далантай) гэсэн утгатай нэр биш, бас ᠶᠡ mis төгсгөлтэй өөр нэр байхыг ч үгүйсгэх аргагүй.

Монголын руни бичгийн дурсгалд ᠶᠡ miš / mis төгсгөлтэй ᠶᠡᠨ ozmiš tigin, ᠶᠡᠨ balamiš (balamaš) ара, ᠶᠡᠨ yätmis ара гэх гурван ч

нэр тохиолдож байна. Хүний нэр бүр утгатай тул тигин, апа цолтны ᠶᠡᠨ ozmiš - Озмиш, ᠶᠡᠨ balamiš (balamaš) – Баламиш (Баламаш), ᠶᠡᠨ yätmis- Йэтмиш нэрс чухам ямар утгатай вэ? гэсэн асуулт гарна.

Эдгээр үгсийг үйл үг гэж үзвэл, ᠶᠡ oz- ял- дийл- үйл язгуурт өнгөрсөн цагийн цагийн ᠶᠡ miš – (juqui, jüküi, san⁴) нөхцөл залгаж ᠶᠡᠨ ozmiš - ялжээ, дийлжээ, ялсан, дийлсэн; ᠶᠡ bala – балба-, цохь- үйл язгуурт мөн өнгөрсөн цагийн цагийн ᠶᠡ miš – (juqui, jüküi, san⁴) нөхцөл залгаж ᠶᠡᠨ balamiš -балбажээ, цохижээ, балбасан, цохисон; ᠶᠡᠨ yäti- хүр-, туул- үйл язгуурт дээрх нөхцөл залгаж ᠶᠡᠨ yätmis- хүрчээ, туулжээ, хүрсэн, туулсан, гүйцсэн гэсэн тухайн үйлийг бүрэн гүйцэтгэсэн буюу гүйцэтгэхийг бэлгэдэх утга агуулга бүхий үйл үг үүсжээ гэж үзэж болохоор байна. Тус үйл язгуураас ᠶᠡᠨ ozmiš - Ялалт, Ялагч, ᠶᠡᠨ balamiš – Балбалт, Балбагч, ᠶᠡᠨ yätmis – Хүрэгч, Туулагч гэсэн утга бүхий нэр үүссэн байж болох юм. Гэхдээ ᠶᠡᠨ yätmis үйл үг үү, тооны нэр үү гэдгийг батлах боломжгүй юм.

Баттай баримт, хангалттай эх хэрэглэгдэхүүн одоогоор хомс ч тухайн үйлийг бүрэн гүйцэтгэсэн буюу гүйцэтгэхийг бэлгэдсэн утга агуулга бүхий нэр өгөх ёс уламжлал Түрэг, Уйгуруудын дунд түгээмэл биш боловч байсныг дээрх жишээ харуулж байна.

Хар хороотын бичээсийг бичих болсон шалтгааныг тодорхой хэмжээгээр тодруулах зайлшгүй шаардлагатай. Бичээсийг тусгайлан хүрээ татаж, хүрэн дотор бичсэн нь тодорхой утга агуулж буй бололтой. Монголын руни бичгийн дурсгалуудаас зорилготойгоор хүрээ татаж бичсэн бичээс одоогоор Хар хороотоос өөр байхгүй байна.

Магадгүй, ᠶᠡᠨ yätmis ара гэх язгууртан тэнгэрт хальсанд, түүнд зориулж үйлдээд хойлго, оршуулгад зориулсан болохыг хүрээгээр төлөөлүүлсэн байх магадлалтай. Нас барсныг хүрээ, хашлагаар төлөөлүүлэх нь хүн төрөлхтний соёлын нийтлэг хэв шинж бөгөөд аль ч соёлд түгээмэл байдаг тэмдэг, тэмдэглэгээ билээ. Өөрөөр хэлбэл, аян замын зуур тэнгэрт хальсан Йэтмиш апа-д тахилын онгон байгуулах боломж, цаг зав байсангүйд чандарлан оршуулаад аравтын дарга бичээс үйлдсэн байж болох юм.

Бичээс байгаа тохиолдолд эргэн тойрны хад чулуунд нэгээс нэгжгээд олон тамга сийлж, цохиж үлдээх нь бага дурсгалын нийтлэг хэв шинж атал Хар хороотын хаданд зураг байхаас бус тамга огт байхгүй байгаа нь бичээс үйлдэгчид маш богино хугацаагаар түр буудалласан, мөн онцгой тохиолдлоор бичээс бичиж үйлдсэн болохыг харуулж байна.

Номзүй

Азаяа, 2018 - Б.Азаяа., Их бичигтийн руни бичгийн дурсгал. ALTAICA, Vol.XIV, УБ. 142–148.

Азаяа, 2021 - Б.Азаяа., Өмнөговь аймгийн нутаг дахь Монголын руни бичгийн дурсгал. The 7th International Conference on Asian Studies, Vol.VII, 64–71.

Амартүвшин нар, 2019- Ч.Амартүвшин., О.Батзориг., Б.Батдалай. Ханбогдын археологийн дурсгал УБ.

Анхбаяр нар, 2023 - Б.Анхбаяр., Б.Мөрөн., Б.Буян-Орших. Хар хороотын руни бичээс, тамга. Археологийн судлал, Том.XLII(fasc. 6). УБ. 79–84. <https://doi.org/10.5564/sa.v42i1.2820>

Баттулга, 1997 - Ц.Баттулга. Их бичигтийн бичээс. МУИС, МСС, Эрдэм шинжилгээний бичиг, Боть 10(122), УБ. 9–13.

Баттулга, 2022a - Ц.Баттулга. Монголын руни бичгийн дурсгалын шинэ судалгаа: Vol. I: Монголын баруун бүс нутаг дахь руни бичгийн дурсгал. УБ.

Баттулга, 2022b - Ц.Баттулга. Монголын руни бичгийн дурсгалын шинэ судалгаа: Vol. II: Монголын төв, умард бүс нутаг дахь руни бичгийн дурсгал. УБ.

Баттулга, 2022c. - Ц.Баттулга. Монголын руни бичгийн дурсгалын шинэ судалгаа: Vol. III: Монголын зүүн, өмнөд бүс нутаг дахь руни бичгийн дурсгал. УБ.

Баттулга, 2023 - Ц.Баттулга. Хар хороотын бичээсийг уншиж судалсан урьдчилсан тайлан. Монгол Улсын Их Сургууль, Ази судлалын тэнхим, Түрэг судлалын салбар. УБ.

Баттулга, 2024 - Ц.Баттулга. Тэвш (Тэгш)-ийн уулаас илрүүлсэн руни бичгийн хоёр шинэ дурсгал. *Mongolian, Journal of Anthropology, Archaeology and Ethnology*, Vol. 13, №1(601). 109–115. <https://doi.org/10.22353/mjaae.2024130109>

Болд, 1987-Л.Болд. Шинээр олдсон түрэг бичээс. Хэл зохиол судлал, Том.XVI(fasc. 6), УБ. 68–71.

Болд, 2006- Л.Болд. Орхон бичгийн дурсгал II. Шинжлэх ухааны академи, Хэл зохиолын хүрээлэн. УБ.

Осава нар, 2020 - Осава Т., Лхүндэв Г., Батзориг О., Батдалай Б. Newly Discovered Runic Inscription and Tamga-Seals From Baishint Khar Mountain (Байшинт Хар уулнаас шинээр илрүүлсэн руни бичээс болон тамга тэмдгүүд). *Studia Archaeologica*, Том.XXXIX(fasc.8), УБ. 98–104. 突厥上. (n.d.). In 通典: Vol. 卷197 (p. 第5402页).



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution

Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.